

БАТЛАВ:  
ХОТ БАЙГУУЛАЛТ ХОТЫН СТАНДАРТЫН  
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ч.ТӨГСДЭЛГЭР

2024 оны 10 дугаар сарын 25

УДИРДАМЖ

2024 оны 10 дугаар сарын 24

Улаанбаатар хот

“ОЛОН ТӨВТ ХОТ- ИРГЭДИЙН ОРОЛЦОО”  
СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

**Нэг. Зорилго:**

Нийслэл Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулж буй түүхэн үйл явцад 20 минутын хот, төрийн болон аж ахуйн үйлчилгээг иргэдэд тэгш хүртээмжтэй хүргэх, авто замын түгжрэлийг бууруулах шийдэл болон олон төвт хотын тогтолцоонд салбарын боловсон хүчинг хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд татан оролцуулах зорилготой.

**Хоёр. Оролцогчдын хамрах хүрээ**

Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургуулийн Хот төлөвлөлт, Архитектур, Газар зохион байгуулалтын салбарын оюутан, судлаачид, мэргэжлийн холбоод, мэргэжилтнүүдийн хүрээнд зохион байгуулна.

**Гурав. Хугацаа, зохион байгуулах газар**

Нэгдүгээр шат:

Эрдэм шинжилгээний хуралд оролцогчдын илтгэлийг 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 17:00 цаг хүртэл хэвлэмэл болон файлаар Хот байгуулалт, хотын стандартын газрын Дэд төв, дагуул хотын хэлтэс (Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23 хороо, Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор “Б” байр, 1021 тоот), цахим шуудангаар ([n.myadagbadam@uda.ub.gov.mn](mailto:n.myadagbadam@uda.ub.gov.mn)) хүлээн авна.

Нийт ирүүлсэн илтгэлүүдээс 8 илтгэлийг Зохион байгуулах комисс сонгон шалгаруулж, хоёрдугаар шатны эрдэм шинжилгээний хурал дээр хэлэлцүүлнэ.

Хоёрдугаар шат:

Нэгдүгээр шатны шалгаруулалтаас шалгарсан 8 илтгэгчтэй Зохион байгуулах комисс 2024 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн дотор холбогдон, эрдэм шинжилгээний хурлын урилга хүргүүлнэ.

Хурал 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 10:00 цагт Нийслэлийн Нутгийн захиргааны төв цогцолбор байр, 1 давхрын “Хүндэтгэлийн танхим”-д болно.

**Дөрөв. Сэдвийн хамрах хүрээ:**

“Олон төвт хот-иргэдийн оролцоо” ерөнхий сэдвийн хүрээнд дараах дэд сэдвүүдийг хамруулна. Үүнд:

1. 20 минутын хотын үзэл баримтлалыг Улаанбаатар хотод хэрэгжүүлэх боломж, шийдэл,
2. Нийслэлийн дагуул хотуудыг бие даан хөгжүүлэх болон төр хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлэх боломж, шийдэл,
3. Эдийн засгийн тусгай бүсийг төр хувийн хэвшлийн түншлэлээр хөгжүүлэх боломж, шийдэл,
4. Үйлдвэр, их дээд сургууль, томоохон зах худалдааны төвүүдийг салбар чиглэл бүрээр хотын дэд төв, дагуул хотуудад нүүлгэн шилжүүлэх боломж, шийдэл,
5. Дахин төлөвлөлтийн үйл ажиллагаанд авч хэрэгжүүлэх арга зам, шийдэл,
6. Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулахад чиглэсэн шийдэл.

**Тав. Илтгэлд тавигдах шаардлага:**

Илтгэл нь Монгол хэлээр, MS Word программ дээр бичигдсэн байх ба цаасны хэмжээ А4, дээд захаас 25 мм, доод захаас 25 мм, баруун захаас 20 мм, зүүн захаас 30 мм, Arial фонд, үсгийн хэмжээ 12, мөр хоорондын зай 1.5 байна. Өгүүллийг бичихдээ Header, footer, footnote ашиглаагүй байна. Нийтээр хэрэглэж заншаагүй товчилсон үгийг өгүүлэлд хэрэглэхгүй байвал зохино. Нийт 4500 үгнээс хэтрэхгүй байна.

Эрдэм шинжилгээний өгүүлэл нь дараах бүтэцтэй байна.

1. Өгүүллийн нэр- Arial фондоор, 14pt, Bold, ТОМ ҮСГЭЭР, мөр голлоно.
2. Зохиогчийн нэр, хаяг- Arial фондоор, 12pt, мөр голлоно. зохиогчдын нэрийн баруун дээд өнцөгт 1,2 гэх мэтээр тэмдэглэн нэрсийн доор зохиогчийн албан газар, сургуулийн нэр байна.
3. Хураангуй- Arial фондоор, 15 мөр 250 үгэнд багтаан, мөрний эхнээс эхлэх ба мөр хоорондын зай 1-ээр бичнэ.
4. Түлхүүр үг - Өгүүллийн санааг гаргахуйц ганц тоогоор 3-5 түлхүүр үг хэрэглэж бичигдэнэ. Өгүүллийн нэрэнд орсон үг түлхүүр үгэнд орохгүй. Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
5. Удиртгал болон оршил хэсэг- Энэхүү хэсэгт судалгааны үндэслэл хэрэгцээ шаардлага, онол, арга зүйн үндэслэл, судлагдсан байдал, тоо баримт гол онцлогуудыг бичнэ. . Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
6. Судалгааны зорилго, зорилт, шинэлэг байдал, ач холбогдол- Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
7. Судалгааны арга зүй, хэрэглэгдэхүүн- /Судалгааны субъект, судлах зүйл, хугацаа, зохион байгуулалт, түүврийн хэмжээ, хэрэглэсэн арга зүй, аргачлал, статистик боловсруулалт гэх мэт/. Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
8. Судалгааны үр дүн, шүүн хэлэлцэхүй- /Судалгаанаас гарсан үр дүнг бусад судлаачдынхтай харьцуулан үнэлж дүгнэж тодорхой бичих/ Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
9. Хүснэгт болон зураг нь өгүүлэлд орсон дарааллаараа дугаарлагдана. Хүснэгт болон зургийн гарчиг нь Arial фондоор, 12pt, мөр голлон (Хүснэгт 1..., Зураг 1... гэх мэт) бичигдэнэ
10. Зургийг JPG форматаар, диаграммыг Microsoft Excel Программ дээр үйлдэнэ.
11. Дүгнэлт- /Үр дүнд тулгуурласан товч тодорхой байх/ Arial фондоор, 12pt, зүүн талдаа зэрэгцэн бичигдэнэ.
12. Санал, зөвлөмж- /Үр дүнд тулгуурласан товч тодорхой санал байвал бичиж болно/
13. Талархал /Уг судалгааг явуулахад тусалсан хамт олон хүмүүсээ бичих/ Илтгэлд ашигласан эх сурвалжийг заавал тэмдэглэх (Иш татсан тохиолдолд тогтсон стандартыг баримтлах);



14. Ашигласан материал: Arīal фондоор, 10рт, зүүн талдаа зэрэгцэн бичигдэх, Өгүүллэгийн төгсгөлд ишлэл татсан ном, сэтгүүл, зохиолын нэрс, вэб хаягийг бичих бөгөөд өгүүлэлд иш татсан дугаараар дугаарлана.

### **Зургаа. Үнэлгээний шалгуур үзүүлэлт.**

#### Нэгдүгээр шатны шалгаруулалтад:

- Судалгааны арга зүй ашигласан байдал;
- Тухайн сэдвийн судлагдсан байдал;
- Шийдэл, шинэ санаа дэвшүүлсэн байдал;
- Ишлэл зүүлт иш татсан байдал;
- Эрдэм шинжилгээний бүтээлд тавигдах шаардлагыг хангасан байдал.

#### Хоёрдугаар шатны шалгаруулалтад:

Нэг дүгээр шатны шалгуураас гадна

- Илтгэх чадвар;
- Илтгэлийн хугацааны цаг ашиглалт дүгнэгдэнэ.

### **Долоо. Шүүгчдийн бүрэлдэхүүн:**

#### Нэгдүгээр шат:

-Зохион байгуулах комисс байна. /5 хүний бүрэлдэхүүн/

#### Хоёрдугаар шат:

- УИХ, Монгол Улсын Засгийн газрын төлөөлөл-1
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын удирдлагын төлөөлөл – 1
- Хот байгуулалт, хотын стандартын газрын удирдлагын төлөөлөл – 1
- Эрдэмтэн, мэргэшсэн судлаачийн төлөөлөл-2

### **Найм. Шагнал урамшуулал:**

Шагналт 5 байр шалгаруулна. Үүнд:

- Тэргүүн байр - Өргөмжлөл, 1.500.000 төгрөг,
- Дэд байр - Өргөмжлөл, 1.000.000 төгрөг,
- Гутгаар байр - Өргөмжлөл, 500.000 төгрөг.
- Тусгай байр 2- Өргөмжлөл, 200.000 төгрөг.

Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн оролцогчдын бүтээлийг эмхэтгэл болгон хэвлүүлж, олон нийтэд хүргэнэ.

### **Ес. Дэмжигч, хамтрагч байгууллагууд:**

#### 1. Дэмжигч:

- 20 минут хот Үндэсний хороо,
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар.
- “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ

#### 2. Хамтрагч:

- Монгол Улсын их сургууль,
- Монгол Улсын шинжлэх ухаан, технологийн их сургууль,
- Хөдөө аж ахуйн их сургууль,